



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 20 өдөр

Дугаар А/884

Ховд

Г Төсөвт зохицуулалт хийх тухай Г

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 42 дугаар зүйлийн 42.2 дахь заалт, 61 дүгээр зүйлийн 61.1 дэх заалт, Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”, 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын сайдын 2019 оны 14/8740 дугаар албан бичиг, төсвийн байгууллагын төсөв захирагч нарын хүсэлтийн дагуу орон нутгийн удирдлагын байгууллагуудын хэмнэгдсэн зардлыг хүрэлцэхгүй байгаа зардлын бүлэг хооронд зохицуулалт хийх жагсаалт, дүнг 1 дүгээр хавсралтаар, тусгай зориулалтын шилжүүлгийн Боловсролын байгууллагуудын төсөвт зохицуулалт хийх жагсаалт, дүнг 2 дугаар хавсралтаар, боловсролын байгууллагуудын төсөв хооронд зохицуулалт хийх жагсаалт, дүнг 3 дугаар хавсралтаар, Эрүүл мэндийн байгууллагуудын төсөвт зохицуулалт хийх жагсаалт, дүнг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Дээрх байгууллагуудын төсөвт зохицуулалт хийж, зарлагын сар, улирлын хуваарьт өөрчлөлт оруулан батлуулж, мөрдөж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал /-д зөвшөөрсүгэй.

3. Дээрх хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулан өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг дарга, төсвийн байгууллагын захирагч нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/884 Ch  
02 04333